



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
<http://www.nccd.gov.mn>


2023. 07. 19 № 3-2 / 1194
танай _____-ны № _____-т

**ЦАХИМ ПРОГРАММ ХАНГАМЖ
ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ХУВЬ ХҮН
БОЛОН БАЙГУУЛЛАГУУДАД**

Тус төвөөс Глобаль сангийн дэмжлэгтэй 2021-2023 онд хэрэгжих төслийн хүрээнд Эрсдэлт бүлгийн хүн амын мэдээллийн цахим санг сайжруулж, шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой байгууллага (хувь хүн)-ын сонгон шалгаруулалтыг хийх шаардлагатай байгаа тул "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу холбогдох материалыг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт 2-ыг хуудастай.

ДЭД ЗАХИРАЛ



Д.БАЯРСАЙХАН



ХӨСҮТ-ийн 2023 оны
тоот албан бичгийн хавсралт

**Эрсдэлт бүлгийн хүн амын мэдээллийн цахим сан программ хангамжийг
хөгжүүлэх байгууллага (хувь хүн)-д тавигдах шаардлага**

- Хувь хүн болон хуулийн этгээд нь дараах үүргийг гүйцэтгэнэ:
- Энэхүү баримт бичигт тусгагдсан мэдээллийн маягтыг мэдээллийн урсгалын дагуу мэдээллийг боловсруулах програм хангамж, онлайн програм, гар утас болон сервисүүдийг шаардлагыг хангасан мэдээллийн нууцлалыг хадгалсан, цогц шийдлийг нийлүүлнэ. Төрийн ХУР болон ЭМД -ийн гаргасан сервисүүдтэй холбох ба мэдээллийг үнэн зөв, бодит цагт дамжуулалт хийдэг байна.
- Халдварт өвчний талаарх Тайлангийн систем буюу хяналтын самбар Веб сайтыг хөгжүүлэхдээ ард иргэд болон хэрэглэгчид гэсэн 2 ангилалаар, мэдээ мэдээлэл, гарын авлага сургалтын материалууд, хяналт самбар, тайлан, файл татаж авах /програмын сайжруулалтууд, хичээлүүд/ гэсэн агуулгатайгаар хөгжүүлнэ.
- Шаардлагатай дэд бүтцээр хангагдах ба сервэр нь виртуалчлалын технологийг ашигласан байна. /Өгөгдөл бааз нь хэт их хэмжээтэй үүсэхгүй тул бодит сервэрийг олон сервэрт хуваан ашиглах боломжтой ба урт хугацаанд ашиглах лизензтэй байна/
- Нийлүүлж буй шийдлүүд ашиглагдах програм хангамжийн лицензийг нийлүүлнэ. Ашиглагдсан програмын лицензийн өртөг гэрээний үнийн дүнд багтсан байна.
- Одоо ашиглагдаж байгаа системүүдийг бүх мэдээллийг алдаагүй хөрвүүлж нийлүүлсэн байна.
- Системийн зааж сургах видео хичээлийг бэлтгэх ба 30 багагүй цагийн хичээлийн танхимаар явуулна.
- Хөгжүүлж бүрэн дууссанаас хойш 3 жилийн хугацаанд засвар үйлчилгээ болон нэмэлт хөгжүүлэлтийг тохиролцсны үндсэн дээр хийж /сургалт, гарын авлагыг шинчлэх/ гүйцэтгэнэ.

- Хөгжүүлж бүрэн дууссанаас хойш 3 жилийн хугацаанд засвар үйлчилгээ болон нэмэлт хөгжүүлэлтийг тохиролцсны үндсэн дээр хийж /сургалт, гарын авлагыг шинчлэх/ гүйцэтгэнэ.
- Хувь хүн болон хуулийн этгээдэд тавигдах шаардлага:
- Сүүлийн 5 жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж, 2-оос дээш програм хөгжүүлэлт хийсэн туршлагатай програм зохиогч нартай байх /4 дээш гишүүнтэй чадвартай, өндөр нарийн мэргэжлийн баг байж болно/
- Сүүлийн 3 жилийн хугацаанд MYSQL, MSSQL өгөгдлийн баазтай ажилладаг систем болон гар утасны аппликейшнийг амжилттай нэвтрүүлж байсан байх
- Тайлан гаргах болон дашбординд хөгжүүлж байсан эсхүл байгууллагын ERP системийг хөгжүүлсэн байсан бол давуу тал болно.
- Цахим гарын үсэг болон хиймэл оюун ухаанд суурилсан төсөл хэрэгжүүлж байсан бол давуу тал болно.
- IOS болон Андроид үйлдлийн системд гар утасны програм хөгжүүлж байсан туршлагатай програм хөгжүүлэгчийн хөгжүүлэлтийн багт заавал оролцуулсан байна. /Хамтарч ажиллах гэрээг байгуулсан байж болно./
- Гар утас, систем болон веб хуудас зэргээс бүрдсэн цогц хөгжүүлэлтийг амжилттай хийсэн шийдэлтэй бол давуу тал болно.
- Систем хөгжүүлсний дараах нэмэлт хөгжүүлэлтийг хариуцан хэрэгжүүлсэн туршлагатай байна.
- Хөгжүүлэлтийн ажил нь эмзэг мэдээлэл хариуцаж ажиллах /хувь хүний мэдээллийн хуулийн дагуу/ тул заавал дотоодын компани байна.
- Бүрдүүлэх материал:
- Тухайн мэдээллийн сан программ хангамжийг хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл
- Байгууллага (хувь хүн)-ын танилцуулга